

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ГЕРМАН-МОНГОЛЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ "ТОГТВОРТОЙ
ХӨДӨӨ АЖ АХУЙ" ТӨСӨЛ

GFA
CONSULTING GROUP
Generalbeauftragter BMEL
Büro Berlin

Нэвтрүүлэх үйлчилгээний аргачлал, арга зүй

Кэвин Галлагер, PhD

Хэрэгжүүлэгч байгууллагууд

IAK
AGRAR CONSULTING

AFCI
AGRICULTURE & FINANCE
CONSULTANTS

DLG
International

Түши байгууллага



NAEC
ХӨДӨӨ АЖ АХУЙН
ҮЙСДЭВЭРҮҮЭЛЭГ ШИНЖЛЭХ
УХААНЫ ОЛОНТ НӨСТРҮҮЛЭХ ТӨС

ГАРЧИГ

1. Нэвтрүүлэх үйлчилгээний аргачлал, арга зүйн тойм
2. Сургалт, нэвтрүүлэлтийн пассив аргууд
3. Сургалт, нэвтрүүлэлтийн актив аргууд

1. Нэвтрүүлэх үйлчилгээний аргачлал, арга зүйн тойм

- Нэвтрүүлэх үйлчилгээнд зорилгоосоо хамаарч сургалт, нэвтрүүлэлтийн төрөл бүрийн арга, хэрэгслүүдийг ашигладаг.
- Арга, хэрэгсэл бүр өөр өөрийн харьцангуй давуу талуудтай.
- Сургалт, нэвтрүүлэлтийн төрөл бүрийн арга, хэрэгслүүдийг ихэвчлэн хослуулсан ашигладаг бөгөөд нийтэд нь “багажны хайрцаг” ч гэж нэрлэдэг.



Сургалт, нэвтрүүлэлтийн “багажны хайрцаг”

- Сургалт, нэвтрүүлэлтийн арга, хэрэгслүүд үргэлж шинэчлэгдэж, шинээр бий болж байдаг.
- Зөв багажуудаа (арга, хэрэгсэл) сонгох шаардлагатай.



Сургалт, нэвтрүүлэлтийн зарим арга, хэрэгслүүд

- Танхимын сургалт (аймаг, суманд)
- YouTube / видео
- Facebook
- Зурагт хуудас/ Брошюр
- Тараах материал
- Мэдээллийн богц
- Телевизийн нэвтрүүлэг /цуврал нэвтрүүлэг
- Цахим сургалт

- Үзүүлэнгийн талбай
- Талбайн өдөрлөг
- Танхимын сургалт
- Лекц/ семинар
- Суралцагчдын бүлэг

- Фермерээс фермерт
- Зөгийн коллеж
- Фермерийн талбайн сургууль
- “Хаалганаас хаалганд”
- Менторинг - Шавь сургалт
- Колл центр / колл ин

- Оролцоот судалгаа
- Төрөлжсөн сургалт
- Мастер цэцэрлэгч
- Пара-Вет
- Сургалтын аялал

← ПАССИВ

АКТИВ →

Мэдлэг дамжуулах аргуудын харьцуулалт: Сурганы пирамид



Source: National Training Laboratories, Bethel, Maine

Зургийн эх сурвалж: www.ntl.org



2. Сургалт нэвтрүүлэлтийн пассив аргууд

Танхимын сургалт (аймагт, суманд)

YouTube / видео

Facebook

Зурагт хуудас / брошюр

Тараах материал

Мэдээллийн богц

Телевизийн нэвтрүүлэг / цуврал

Үзүүлэнгийн талбай

Танхимын сургалт

Цахим сургалт

Талбайн өдөрлөг

Лекц / семинар

Суралцагчдын бүлэг




Цахим сургалт зохион байгуулах

- Аймаг, суман дахь сургалтын танхимд, эсвэл ухаалаг гар утсаар дамжуулан зохион байгуулж болно.
- Шаардагдах зүйлс: LED зурагт эсвэл проектор, HDMI кабель, зөөврийн компьютер, интернет
- YouTube, видео татаж авах (маузын баруун товчийг дарж видеоны URL-ийг хуулж авна)
- <https://www.onlinevideoconverter.com/> сайт ашиглан видео татаж авч, интернэтгүй үед ашиглах боломжтой.




Зургийн эх сурвалж: Зохиогч

Цахим сургалт зохион байгуулах




Фэйсбүүкээр шууд (лайв) бичлэг цацах



“go live”
дарна

Товч
танилцуулга
бичиж болно



Бичлэгийг
эхлүүлнэ

Зургийн эх сурвалж: Зохиогч

Цахим сургалт зохион байгуулах

Монгол хэл дээрх ном, судалгааны тайлангууд:

- <http://books.xxaa-zainii-surgalt.mn/> цахим номын сан
- ХААҮШУОНТ-ийн номын сан

Цахим сургалтын жишээ:

- ЕХ-ны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн цахим сургалт [Хүхэрт устөрөгчтэй хэрхэн харьцах вэ](#)

Зургийн эх сурвалж: <http://books.xxaa-zainii-surgalt.mn>

Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэр
posted Dec 3, 2018, 10:44 AM by Purevjav Tumendemberel



Сургалт, яриа, хэлэлцүүлэг

■ Танхимын сургалт

- Төлөвлөлтөд тустай. Гэвч сурсан зүйлсээ сүүлд нь хэрэг болох үед мартаж эрсдэлтэй.
- Шинэ бүтээгдэхүүн, технологи сурталчилж, нэвтрүүлэхэд тохиромжтой.

■ Семинар / лекц

- Зочин илтгэгчид тэргүүний малчид, тариаланчдыг урьж болно.
- Facebook, Skype ашиглан зайнаас оролцож болно


■ Суралцагчдын бүлэг

- Тодорхой сэдэв сонгож, уншиж судлах материал цуглуулна. Тодорхой хугацаанд (жишээ нь 2-3 сарын турш) тогтмол уулзана. Хамтдаа видео бичлэг үзэж, хэлэлцүүлэг өрнүүлнэ. Суралцагчдын бүлгүүд тодорхой ажлууд төлөвлөж, хамтран гүйцэтгэдэг туршлага ч бий. (жишээ нь шүлхий өвчинтэй тэмцэх талаар)



Телевизийн нэвтрүүлэг

- Нэг нэвтрүүлэгт нэг л тодорхой асуудлыг хөндөнө – жишээ нь брүцеллэз өвчинтэй тэмцэх, эсвэл хүлэмжинд гүзээлзгэнэ ургуулах тухай г.м.
 - Өвлийн улиралд тохиромжтой? [мартагдах эрсдэлтэй тул бичлэгийг YouTube-д хадгалж, сүүлд нь дахин үзэх боломжтой байвал зүгээр]
- Долоо хоног бүрийн цуврал хөтөлбөр байж болно. Жишээ нь мал маллагааны талаар телевизийн цуврал хичээл жилийн турш явуулж, тухайн долоо хоног бүрт малд ямар арчилгаа, маллагаа шаардлагатайг үзүүлэх, эсвэл бэлчээрийн зохистой ашиглалтыг улирал бүрээр үзүүлэх
 - Бодит цаг хугацаанд суралцах тул суралцагчдын суралцах идэвх, эрмэлзэл сайн байдаг.
- YouTube суваг ажиллуулах



Зургийн эх сурвалж: Зохиогч

Талбайд зохион байгуулах арга хэмжээ

■ Талбайн өдөрлөг

- Түгээмэл ашиглагддаг – үлгэр жишээ болохуйц талбайг сонгох буюу өөрөө ийм талбай зориуд бэлтгэнэ. (мал аж ахуйд ч энэ зарчмыг баримтална)
- Оролцогчдод мэдээллийн материал, зурагт хуудас тараана.
- Плакат буюу самбар дээр гол мессежүүдээ бичиж байрлуулна.

■ Үзүүлэнгийн талбай / Үзүүлэнгийн сүрэг бэлтгэх

- Хяналттай нөхцөлд бэлтгэнэ.
- Байнгын арчилгаа, хяналтад байлгана.
- Үзүүлэнгийн жишээ:
 - тэжээлийн ургамлын тариалангийн технологи үзүүлж сурталчлах
 - малын үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээнүүдийг танилцуулах

3. Сургалт, нэвтрүүлэлтийн актив аргууд

Фермерээс фермерт

Зөгийн коллеж

Фермерийн талбайн сургууль

Оролцоот судалгаа

Менторинг – Шавь сургалт

Сургалтын аялал (гадаадад)

Хаалганаас хаалганд

Колл центр / Колл ин

Төрөлжсөн сургалт

Мастер цэцэрлэгч

Пара-Вет



Зургийн эх сурвалж: Зохиогч

Эрчимжсэн практик сургалт

■ Фермерээс фермерт / Малчнаас малчинд

- Орон нутгийн тэргүүний фермер бусад фермерийн урилгаар зочилж, туршлага, арга барилаасаа хуваалцана. Нутгийн фермерийн зөвлөгөө гадны мэргэжилтнийхээс илүү бодитой, хэрэгцээтэй байх нь элбэг.

■ Зөгийн коллеж

- Жил бүр 2 хоногийн лекц, семинар, талбайн дасгал ажил хосолсон сургалт зохион байгуулна – анхан болон ахисан шатанд. Оролцогчид хоорондоо танилцаж, цаашид хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ.

<https://entnemdept.ifas.ufl.edu/honey-bee/extension/bee-college/>



Зургийн эх сурвалж: www.wyomingbeecollege.org

Эрчимжсэн практик сургалт

■ Фермерийн талбайн сургууль (Farmer Field School)

- Тариалалтын буюу МАА-н үйлдвэрлэлийн нэг бүтэн сезоны туршид явагддаг практик ур чадварын сургалт – жишээ нь саалийн үнээний маллагаа, хүлэмжийн тариалалт г.м.
- Тогтмол давтамжтай бүлгийн уулзалтууд (сэдвээс хамаарч долоо хоног тутам, эсвэл сар бүр) зохион байгуулна.
- Оролцогчдын практик ур чадвар, арга ажиллагааг алхам алхамаар нэг бүрчлэн сайжруулахад чиглэнэ. Маш үр дүнтэй.
- Хэд хэдэн байршилд нэг зэрэг зохион байгуулах бол байршил бүрт сургагч багш бэлтгэнэ.
- 90 гаруй оронд 30 жилийн турш туршигдаж, шалгарсан аргачлал.
- <http://www.fao.org/farmer-field-schools/en/> хаягаас дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

Эрчимжсэн практик сургалт

■ Менторинг, Шавь сургалт

- Ахмад малчин, фермер нутгийнхаа залуучуудад ганцаарчлан зааж, зөвлөдөг.
- Хот суурингаас хөдөө шилжиж ХАА-н үйлдвэрлэл шинээр эрхэлж буй хүмүүст нэн тохиромжтой бөгөөд Монголд харьцангуй түгээмэл.
- Фермерийн талбайн сургууль, техник мэргэжлийн сургалттай хослуулах боломжтой



Зургийн эх сурвалж: Зохиогч

Бусад аргууд

■ Хаалганаас хаалганд

- Айл бүрт зочилж, зөвлөгөө өгнө. Итгэлд суурилсан харилцаа бий болгоно.
- Жишээ нь: мал вакцинжуулалт.

■ Колл центр/ Колл-ин

- Ухаалаг утасны хэрэглээ нэмэгдэж, хүн бүр утсаар ярих, мессеж бичих, фото зураг авах, бусдад илгээх боломжтой болж байна. Колл центр бүрт хэд хэдэн мэргэжилтэн ажиладаг (зарим нь тэтгэвэрт суусан). “Центр (төв)” нь бодит буюу цахим орчинд байж болно.
- Утасны дугаарыг наалт (стикер) дээр хэвлэнэ.
- [Guidelines-for-Agri-Call-Centres.pdf](#) хаягаас дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.
- Цаг агаар, тэжээлийн үнийн мэдээллийг ОБЕГ ба Мери Короос авна.

Бусад аргууд

■ Сэдэвт сургалт

- Тодорхой сэдвээр явагддаг богино хугацааны онол, практикийн сургалт. Монголд харьцангуй түгээмэл. Тухайн сэдвээр мэргэшсэн багш, мэргэжилтнүүд хичээл заадаг.
- Жишээ нь: Нарны халаалалттай хүлэмж хэрхэн барих вэ? Арьс өвчих хутгыг хэрхэн ашиглах вэ?

■ Мастер цэцэрлэгч

- Цэцэрлэгийн аж ахуй эрхлэгчид буюу сонирхогчдоос тодорхой хүмүүсийг сонгож, мэргэшүүлэх замаар зөвлөх цэцэрлэгч буюу орон нутгийн сургагч багш бэлтгэх хөтөлбөр. Ихэвчлэн фермерийн талбайн сургууль төгсөгчдөөс сонгодог.
- Мастер цэцэрлэгчдийн сүлжээ үүсгэдэг.

■ Пара-Вет

- Мастер цэцэрлэгчтэй төстэй, гэхдээ мал маллагаанд чиглэсэн. Сургагдаж бэлтгэгдсэн малчид хөрш малчиддаа үржил, мал эмнэлэг, бэлчээрийн менежментийн чиглэлээр зааварлаж, зөвлөдөг.

Эрчимжсэн практик сургалт

■ Сургалтын аялал

- Амжилттай туршлагаас газар дээр нь суралцах зорилготой. Дотоодод буюу гадаадад зохион байгуулж болно.
- Шинэ санаа, сэдэл төрүүлэх: бусдын амжилттай хэрэгжүүлсэн туршлагаас санаа авч, өөрийн нөхцөлд хэрэгжүүлэх бодит санал, санаачлага гаргах, төлөвлөх.
- Жишээ нь: ADRA-гаас БНСУ-д зохион байгуулсан органик газар тариалангийн туршлага судлах аялал